



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 41.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/189 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эмнэлгийн хэрэгслийг хэрэглэгчийн эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийн зэргээр ангилах журам, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт"-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тус ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн дотор гүйцэтгэж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг (Р.Энхсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн гишүүдийн илүү цагаар ажилласан хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль болон зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах нягтлан бодогч (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2021 оны А/195 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Л.ЗЭНДМАА



1423 010050



Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20~~13~~ оны 03 дугаар сарын 04 -ны
өдрийн 1/56 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын дарга

Дэд дарга:

Эмийн үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Гишүүд:

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч (зөвшилцсөнөөр)

Шинэ эм, эмнэлзүйн судалгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч

Эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэт нөлөөт эмийн импорт, экспортын лицензын асуудал хариуцсан мэргэжилтэн

Вакцин, биобэлдмэлийн хангамж, хүртээмж, ложистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Хуурамч, стандартын бус эмийн тандалт, судалгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын асуудал хариуцсан мэргэжилтэн

Үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эм, эмийн түүхий эдийн бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Чанар хариуцсан ахлах мэргэжилтэн

Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төслийн эмийн чанар, аюулгүй байдлын зөвлөх (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Биологийн идэвхт бүтээгдэхүүн, протез, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, судалгаа, мэдээллийн сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн